

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ- 67
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАНДАРТ, ГЭРЧИЛГЭЭ

ИНД-67-д 2010.05.07-ны өдрөөс хойш хийгдсэн нэмэлт, өөрчлөлтүүд:

Нэмэлт өөрчлөлт-1 /Зам, тээврийн Сайдын 2013.01.22-ны 14-р тоот тушаал/

*1/ 67.55 “Эрүүл мэндийн үзлэг” зүйлд (б) болон (в) хэсгийг нэмж оруулсан.
2/“Эрүүл мэндийн хяналтын мэргэжилтэн” гэснийг “Эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээд” гэж өөрчилсөн.*

ГАРЧИГ

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
67.1 Зорилго	3
67.3 Тодорхойлолт	3
67.5. ИНЕГ-ын Эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээд	3
67.7. Мэдээллийг нууцлах	3
67.9. Эрүүл мэндийн гарын авлага	4
67.11. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх	4
Б БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГЭРЧИЛГЭЭ	4
67.51. Ерөнхий шаардлага	4
67.53. Өргөдөл гаргах	4
67.55. Эрүүл мэндийн үзлэг	4
67.57. Эрүүл мэндийн гэрчилгээ /ЭМГ/ олгох	5
67.59. ЭМГ-г сунгах, түдгэлзүүлэх	5
67. 61 ЭМГ-г нөхөн олгох	5
67.63 ЭМГ-ний ангилал, хугацаа	5
67.65. ЭМГ-г хүлээн зөвшөөрөх	6
В БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ШААРДЛАГУУД	6
67.101. Ерөнхий шаардлага	6
67.103. Эмнэлгийн үзлэг, дүгнэлтэнд тавигдах шаардлага	6
67.105. Эмнэлгийн тусгай үзлэг	7
Г БҮЛЭГ. ШИНЖЭЭЧ ЭМЧ	7
67.151. Шинжээч эмчид тавигдах шаардлага	7
67.153. Шинжээч эмчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргах	7
67.155. Шинжээч эмчийн үнэмлэх	7
67.157. Шинжээч эмчийн эрх, үүрэг	7
67.159. Бусад зүйлс	8
Хавсралт “А”	9
Эрүүл мэндийн 1 дүгээр ангиллын гэрчилгээ авахаар	9
өргөдөл гаргагчид тавих шаардлага	9
Хавсралт “Б”	14
Эрүүл мэндийн 2 дугаар ангиллын гэрчилгээ авахаар	14
өргөдөл гаргагчид тавих шаардлага	14
Хавсралт “В”	20
Эрүүл мэндийн 3 дугаар ангиллын гэрчилгээ авахаар	20
өргөдөл гаргагчид тавих шаардлага	20

*Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын
2010 оны 05 дугаар сарын 07 –ны өдрийн
160 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт*

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ- 67
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАНДАРТ, ГЭРЧИЛГЭЭ**

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

67.1 Зорилго

(а) Иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцох нисэх багийн гишүүн болон нислэгийн удирдагч нарт эрүүл мэндийн гэрчилгээ олгох, шинжээч эмч нарт тавигдах шаардлагыг тодорхойлоход энэ дүрмийн зорилго оршино.

67.3 Тодорхойлолт

Сэтгэцэд нөлөөлөх бэлдмэлүүд гэж архи, хар тамхи, мансууруулах эм, *сэтгэцэд нөлөөлөх бодис*, каннабис, кокаин болон бусад психостимулятор, хий үзэгдэл үүсгэдэг бодисууд, хий шингэн уусмалууд (үүнд тамхи болон кофе хамаарахгүй).

Шинжээч эмч гэж ИНЕГ-ын хамтран ажиллахаар гэрээ байгуулсан эмнэлгийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр энэ дүрмийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-ын даргаас томилсон, эмчлэх эрх бүхий нарийн мэргэжлийн эмчийг;

Эрүүл мэндийн гэрчилгээ (цаашид ЭМГ гэх) гэж энэ дүрэмд заасан эрүүл мэндийн шаардлагыг хангасан нисэх багийн гишүүн болон нислэгийн удирдагч нарт Иргэний нисэхийн ерөнхий газраас олгох бичиг баримтыг;

Эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт гэж нисэх багийн гишүүн болон нислэгийн удирдагч нарт эрүүл мэндийн үзлэг хийсэн шинжээч эмч нарын тавьсан онош дээр үндэслэн Эрүүл мэндийн гэрчилгээ олгох эсэх талаар эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээдийн гаргах дүгнэлтийг;

67.5. ИНЕГ-ын Эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээд

(а) Эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээд нь өргөдөл гаргагчид ЭМГ олгох, сунгах, эсхүл гэрчилгээг түдгэлзүүлэх дүгнэлт гаргана.

(б) Эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээд нь шинжээч эмчийн тавьсан онош, үзлэгийн тэмдэглэлд тулгуурлан өргөдөл гаргагчид эрүүл мэндийн дүгнэлт гаргах мэргэжлийн чадавхитай байна.

67.7. Мэдээллийг нууцлах

(а) Өргөдөл гаргагчийн зүгээс ЭМГ авах зорилгоор өгсөн аливаа мэдээллийг зөвхөн гэрчилгээ олгох зорилгод ашиглана.

(б) ЭМГ эзэмшигч нь эрүүл мэндийн шаардлагыг хангаж чадахгүй болсон тохиолдолд энэ тухайгаа Эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

(в) Эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээд болон шинжээч эмч нь энэ зүйлийн (а) болон (б) хэсэгт заасан, хувь хүний эрүүл мэндийн талаарх мэдээллийн нууцыг хадгална.

67.9. Эрүүл мэндийн гарын авлага

(а) ИНЕГ-ын эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээд болон шинжээч эмч нь үйл ажиллагаандаа ашиглах ИНЕГ-ын даргын баталсан Эрүүл мэндийн гарын авлагатай байх бөгөөд үүнд өргөдөл гаргах болон эрүүл мэндийн үзлэгийн талаарх зөвлөмж, мэдээллийг багтаасан байна.

67.11. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх

(а) Энэ дүрмийн 67.63-ын шаардлагуудаас аливаа этгээдийг чөлөөлөхгүй.

Б БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГЭРЧИЛГЭЭ

67.51. Ерөнхий шаардлага

(а) Иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцож буй нисэх багийн гишүүн, нислэгийн удирдагч нь энэ дүрмийн дагуу ЭМГ эзэмшигч байна.

67.53. Өргөдөл гаргах

(а) Нисэх багийн гишүүн, нислэгийн удирдагч нь ИНЕГ-067/01 болон ИНЕГ-067/02 маягтын дагуу өргөдөл гаргаж, дараах бичиг баримтыг хавсарган ИНЕГ-т ирүүлнэ:

- 1/ шинжээч эмчээс тавьсан оношууд;
- 2/ сэтгэл зүйн судалгааны дүгнэлт;
- 3/ хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх;
- 4/ төлбөрийн баримт;
- 5/ хэрэв өмнө нь ЭМГ олгогдсон бол тухайн ЭМГ.

(б) Өргөдөл гаргагчид дараах зүйлийг хориглоно:

- 1/ гэрчилгээ авахын тулд алдаатай буюу хуурамч мэдээлэл өгөх;
- 2/ тайлан, эмнэлгийн үзлэгийн онош, тэмдэглэлд засвар хийх;
- 3/ гэрчилгээнд засвар хийх, хуурамчаар үйлдэх.

67.55. Эрүүл мэндийн үзлэг

(а) Дүрэмд тусгайлан өөрөөр заагаагүй бол, эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулахаар өргөдөл гаргасан этгээдэд хийгдэх эрүүл мэндийн түвшин тогтоох үзлэг нь эрүүл мэндийн гэрчилгээ шинээр эсхүл анх олгоход хийгддэг эрүүл мэндийн үзлэгтэй ижил түвшинд хийгддэг байна.

(б) Иргэний нисэхийн ерөнхий газар нь үнэмлэх эзэмшигчийн эрүүл мэндийн түвшинг тогтооход дараах зарчмыг баримтална:

1/ Нислэгийн үед хөдөлмөрийн чадвар алдах тохиолдлууд болон эмнэлгийн үзлэгээр илэрсэн тохиолдлуудад тогтмол дүгнэлт хийж эрүүл мэндийн эрсдэл ихтэй бүлгийг тогтоох; ба

2/ Эрүүл мэндийн эрсдэл ихтэй бүлгийг тогтоох зорилгоор эрүүл мэндийн үзлэгийн явцад дахин үнэлгээг тогтмол хийж байх.

(в) Иргэний нисэхийн ерөнхий газрын эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээд нь өргөдөл гаргагчийн эрүүл мэндийн байдалд хийсэн үзлэг шинжилгээний дэлгэрэнгүй дүн, оношийг үндэслэн эрүүл мэндийн гэрчилгээ олгох эсэх асуудлаар дүгнэлт гаргах ба хуулбарыг өргөдөл гаргагчид өгнө.

67.57. Эрүүл мэндийн гэрчилгээ /ЭМГ/ олгох

(а) Эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээдийн гаргасан эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлтийг үндэслэн ИНЕГ-ын дарга, эсхүл эрх шилжигдсэн эрх бүхий этгээд энэхүү дүрмийн дагуу тухайн ангиллын ЭМГ-г олгоно.

67.59. ЭМГ-г сунгах, түдгэлзүүлэх

(а) ЭМГ эзэмшигч нь ЭМГ-ний хүчинтэй хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө гэрчилгээ сунгуулах тухай өргөдлийг ИНЕГ-067/01 болон ИНЕГ-067/02 маягтын дагуу гаргана.

(б) ЭМГ-ний хүчинтэй хугацаа дуусах үед гэрчилгээ эзэмшигч алсад ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа тохиолдолд эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээдийн дүгнэлтээр ЭМГ-ний хүчинтэй хугацааг дор заасан хугацаагаар сунгаж болно:

1/ 1 дүгээр ангиллын ЭМГ-г – 1 сар хүртэл;

2/ 2 ба 3 дугаар ангиллын ЭМГ-г - 3 сар хүртэл.

(в) Энэ зүйлийн (б) хамааралтайгаар, ЭМГ-ний хүчинтэй хугацааг, өргөдөл гаргагчийн эрүүл мэндийн талаар эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээдийн дүгнэлт гарсан өдрөөс эхэлж тооцно.

(г) ЭМГ эзэмшигч нь биеийн эрүүл мэндийн байдлын хувьд энэ дүрмийн шаардлагыг хангахгүй болсон нь үзлэг шалгалтаар тогтоогдсон тохиолдолд ИНЕГ-ын дарга гэрчилгээг түдгэлзүүлнэ.

67. 61 ЭМГ-г нөхөн олгох

(а) ЭМГ-г үрэгдүүлсэн, гэмтээсэн, бичилт нь гаргацгүй болсон тохиолдолд гэрчилгээг нөхөн олгоно.

(б) ЭМГ эзэмшигч нь гэрчилгээг нөхөн олгох тухай хүсэлтийг ИНЕГ-067/01 болон ИНЕГ-067/02 маягтын дагуу гаргаж, төлбөрийн баримт, ЭМГ-г үрэгдүүлсэн тухай хуулийн байгууллагад мэдэгдсэн, эсхүл зарлуулсан баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ

67.63 ЭМГ-ний ангилал, хугацаа

(а) ЭМГ-г энэ дүрмийн дагуу, дараах ангиллаар олгоно:

Хүснэгт 1

№		1 дүгээр ангиллын гэрчилгээ	2 дугаар ангиллын гэрчилгээ	3 дугаар ангиллын гэрчилгээ
I.	Мэргэжлийн үнэмлэхний төрөл	Нисгэгч, нисэх инженер, штурман	Хувийн нисгэгч, сурагч нисгэгч	Нислэгийн хөдөлгөөний удирдагч
II.	Хугацаа	- 40 нас хүрээгүй бол 12 сар хүртэл; - 40 ба түүнээс дээш настай бол 6 сар хүртэл;	- 40 нас хүрээгүй бол 24 сар хүртэл; - 40 ба түүнээс дээш настай бол 12 сар хүртэл;	- 40 нас хүрээгүй бол 24 сар хүртэл; - 40 ба түүнээс дээш настай бол 12 сар хүртэл;
III.	Шаардлага	Энэ дүрмийн 67.101 болон Хавсралт А-д заасан шаардлагыг хангана.	Энэ дүрмийн 67.101 болон Хавсралт Б-д заасан шаардлагыг хангана.	Энэ дүрмийн 67.101 болон Хавсралт В-д заасан шаардлагыг хангана.

67.65. ЭМГ-г хүлээн зөвшөөрөх

(а) Чикагогийн конвенцийн Хэлэлцэн тохирогч аль нэг улсын эрх бүхий байгууллагаас олгосон эрүүл мэндийн гэрчилгээг ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрч болно.

В БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ШААРДЛАГУУД

67.101. Ерөнхий шаардлага

(а) Өргөдөл гаргагчийн хувьд өмнө нь тухайн ажил үүргийг биелүүлэхэд саад болох эрүүл мэндийн ямар нэгэн эрсдэлт хүчин зүйл болон дараах өвчний түүх нээгдээгүй байна:

- 1/ төрөлхийн буюу олдмол гажиг;
- 2/ идэвхитэй буюу сэдэрсэн үедээ байгаа хурц, эсхүл архаг өвчин;
- 3/ хагалгаа болон ослоос үүдсэн шарх, гэмтэл, бусад хүндрэл;
- 4/ хорт хавдрын процесс;
- 5/ тохирсон эмчилгээгүй халдвар болон бүх биеэр тархсан үжил;
- 6/ архаг ядаргаа, нойргүйдэл;
- 7/ сэтгэцийн архаг болон хурц эмгэг.

(б) Өргөдөл гаргагч нь:

- 1/ аливаа нэг эм бэлдмэл тогтмол хэрэглэдэггүй, байнгын үргэлжилсэн эмчилгээгүй байх, эсхүл
- 2/ эм бэлдмэл хэрэглэснээс үүдэн гарах гаж нөлөө илрээгүй байх шаардлагатай.

67.103. Эмнэлгийн үзлэг, дүгнэлтэнд тавигдах шаардлага

(а) Эмнэлгийн үзлэг, дүгнэлт нь дор дурдсан хугацаанд хүчинтэй байна:

- 1/ нарийн мэргэжлийн шинжээч эмчийн үзлэг - 60 хоногийн дотор;
- 2/ зүрхний цахилгаан бичлэг, аудиограмм хийгдсэн болон рентген зураг авснаас хойш -90 хоногийн дотор;
- 3/ цус, шээсний ерөнхий шинжилгээ- 30 хоногийн дотор;
- 4/ биохимийн шинжилгээ- 45 хоногийн дотор.

67.105. Эмнэлгийн тусгай үзлэг

(а) Энэ дүрмийн 67.63-ын Хүснэгт 1-ийн III-т заасан шаардлагыг хангаагүй өргөдөл гаргагч эмнэлгийн тусгай үзлэг хийлгэж болно.

(б) Хэрэв эмнэлгийн тусгай үзлэгийн дүгнэлтээр гэрчилгээ олгох боломжгүй нь нотлогдвол өргөдөл гаргагч ЭМГ олгохыг шаардах эрхгүй.

(в) ЭМГ эзэмшигчийг дараах тохиолдолд гэрчилгээний хүчинтэй хугацааг үл харгалзан эмнэлгийн үзлэгт орохыг шаардана:

- 1/ эрүүл мэндийн байдалд нь өөрчлөлт орсон;
- 2/ нислэгийн осол, зөрчилд орсон;
- 3/ удаан хугацаагаар (3 сараас дээш) мэргэжлийн ажлаас завсардсан.

(г) Өргөдөл гаргагч эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээдийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тухайн дүгнэлт, хязгаарлалтыг хянаж үзэхийг ИНЕГ-ын даргаас хүсэх эрхтэй.

Г БҮЛЭГ. ШИНЖЭЭЧ ЭМЧ

67.151. Шинжээч эмчид тавигдах шаардлага

(а) Шинжээч эмчээр томилогдохоор өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай;
- 2/ нисэхийн анагаах ухааны чиглэлээр сургалтанд хамрагдсан;
- 3/ ЭМГ эзэмшигчийн ажлын байрны орчин нөхцөлтэй танилцсан;
- 4/ эмчлэх эрхийн хүчин төгөлдөр лицензтэй.

67.153. Шинжээч эмчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргах

(а) Шинжээч эмчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-067/03 маягтын дагуу өргөдөл гаргаж, төлбөрийн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ.

67.155. Шинжээч эмчийн үнэмлэх

(а) Өргөдөл гаргагч нь шинжээч эмчид тавигдах шаардлагыг хангасан тохиолдолд ИНЕГ-ын даргаас шинжээч эмчээр томилсон үнэмлэх олгоно.

67.157. Шинжээч эмчийн эрх, үүрэг

(а) Шинжээч эмчийн эрх:

- 1/ 1, 2, 3 дугаар ангиллын ЭМГ олгохтой холбоотой үзлэг шинжилгээг хийж, онош тавих;
- 2/ өргөдөл гаргагчийн, 90 хоногоос өмнө хийлгэсэн үзлэг шинжилгээний тайлан, дүгнэлтийг хүчингүйд тооцож, дахин үзлэг шинжилгээнд хамруулах.

(б) Шинжээч эмчийн үүрэг:

- 1/ өргөдөл гаргагчид эрүүл мэндийн үзлэгийг чанартай, шудрага, шуурхай явуулах ба өөрийн гаргасан үзлэгийн дүгнэлт, тайлан мэдээ үнэн зөв гэдгийг батлан хариуцах;
- 2/ үзлэг шинжилгээний дүгнэлтийг холбогдох маягтын дагуу (ИНЕГ-067/04-чих хамар хоолойн эмчийн үзлэгийн хуудас, ИНЕГ-067/05-зүрх судасны эмчийн үзлэгийн хуудас, ИНЕГ-067/06-нүдний эмчийн үзлэгийн хуудас ИНЕГ-067/07-мэдрэлийн эмчийн үзлэгийн хуудас)-ыг ИНЕГ-т ирүүлэх;
- 3/ шинжээч эмч нь үзлэг шинжилгээ, оношлогоондоо энэ дүрмийн Хавсралт А, Б болон В-г мөрдлөг болгох;
- 4/ эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах.
- 5/ ажлын байр, байршил, утас, факс зэрэг харилцах хаяг өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 10 хоногийн дотор ИНЕГ-т мэдэгдэх.

67.159. Бусад зүйлс

(а) Шинжээч эмчийн ажлын хөлс, үнэлгээг ИНЕГ-ын даргатай байгуулсан гэрээгээр зохицуулна.

(б) Томилогдсон шинжээч эмч өргөдөл гаргагчийн эрүүл мэндийн талаар санаатайгаар буруу мэдээлэл гаргаж өгсөн тохиолдолд асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлнэ.

---оОо---

ХАВСРАЛТ “А”

ЭРҮҮЛ МЭНДИЙН 1 ДҮГЭЭР АНГИЛЛЫН ГЭРЧИЛГЭЭ АВАХААР ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

Эрүүл мэндийн 1 дүгээр ангиллын гэрчилгээ авахаар Өргөдөл гаргагчид ИНД-67.101-д заасан ерөнхий шаардлагаас гадна энэ Хавсралтад заасан шаардлагууд тавигдана:

1. Сэтгэл мэдрэлийн өвчин:

(а) бүрэн эмчлэгдсэн хордлогын шалтгаантайгаас бусад, сэтгэл мэдрэлийн хурц эмгэг (психоз), солиорол;

(б) согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг, эсхүл түүнээс хамааралтай байдалд орсон (биеийн эрүүл мэнд болон ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд нь сөргөөр нөлөөлөх хэмжээгээр архи хэрэглэдэг болох нь тогтоогдсон);

(в) эмийн бодисоос хамааралтай байдал /эмийн тусламжтайгаар хэвийн байдлаа хадгалах г.м./;

(г) зан төрхийн өөрчлөлт орсон, тэр нь ямар нэг байдлаар илэрдэг;

(д) сэтгэцийн хэвийн бус байдал, хүнд хэлбэрийн психоневроз;

(е) сэтгэл гутрал, депресс.

Өргөдөл гаргагч нь энэ хэсгийн (а)-(е)-д дурдсан өвчний аль нэгээр өвчний түүх нээлгэсэн боловч эмчлүүлээгүй, онош нь бүрэн батлагдаагүй нөхцөлд нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл 2 жилийн хугацаанд оношийг бүрэн батлах нарийн шинжилгээ хийлгэх ба энэ хугацаанд “түр тэнцэхгүй” гэж үзнэ.

Архины цагаан солиотой гэсэн оноштой, эсхүл согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэдэг этгээдээс бусад өргөдөл гаргагч нь шинжээч эмчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байвал дараах шаардлагыг хангасан тохиолдолд 67.105 (г)-д заасны дагуу эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээдийн дүгнэлт, хязгаарлалтыг хянаж үзэхийг ИНЕГ-аас хүсэх эрхтэй:

- архины эмчилгээ хийгдсэний дараа тухайн этгээд бүрэн эмчлэгдсэн тухай нарколог эмч баталгаа гаргасан;

- нислэг үйлдэх эрхээ авсан хугацаанд согтууруулах ундаа хэрэглэхгүй гэсэн баталгаа гаргасан.

2. Мэдрэлийн өвчин:

(а) татаж унадаг өвчин /эпилепси/;

(б) үе үе ухаан алддаг;

(в) мигрень /толгой таллаж өвдөх/ болон бусад хүнд хэлбэрийн толгойн өвдөлтүүд;

(г) тархи нугасны гэмтэл болон мэс заслын үлдэц нөлөө нь эрх үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулахуйц байвал.

3. Яс, тулгуур эрхтэн тогтолцооны эмгэг:

Яс, арьс, үе, булчин, холбогч эд, шөрмөсний ямар нэг өвчний идэвхитэй хэлбэр, төрөлхийн болон гэмтэл, мэс заслаас үүдэлтэй яс, үе, булчин, шөрмөс, холбогч эдийн өвчний улмаас үүссэн бие махбодийн үйл ажиллагааны хэвийн бус байдал багтана.

4. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг:

Хоол боловсруулах эрхтнүүд, элэгний үйл ажиллагааг их хэмжээгээр алдагдуулсан архаг ба хурц өвчин эмгэгүүд, халдварт өвчнүүд, хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэдэг аливаа эмгэг, гэмтлээс үүдэлтэй эмгэг болон хагалгааны дараах байдал, ивэрхий багтана.

5. Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг:

Цээжний хөндийн ямар нэг хурц, идэвхитэй хэлбэрийн өвчин, гэмтэл, уушиг, уушигны гялтан хальс, амьсгалын замын ямар нэгэн халдвар, өндөрт нисэх үед хөдөлмөрийн чадвар гэнэт алдагдах шалтгаан болохуйц аливаа өвчин эмгэг /гуурсан хоолойн багтраа гэх мэт/, эсхүл хагалгаа багтана. Эрүүл мэндийн 1 дүгээр ангиллын гэрчилгээ эхлэн авахын тулд рентген шинжилгээ зайлшгүй хийлгэх шаардлагатай.

6. Зүрх судасны эмгэг:

Зүрх, цусны эргэлтийн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал бүхий дараах өвчин эмгэгүүд:

(а) зүрхний бах, шигдээс, хүндэрсэн хэлбэрийн цусны даралт ихсэлт;

(б) зүрхний хэмнэл алдагдах /пейсмейкер шаардлагатай/;

(в) зүрхний булчингийн агших чадвар сулрах;

(г) зүрхний титэм судасны эмгэг;

(д) зүрхний булчингийн, хавхлагийн, дамжуулах тогтолцооны эмгэг;

(е) гиссийн багцны зүүн, баруун салааны хориг;

(ж) эмчилгээний үр дүн муутай зүрхний дутагдал буюу хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэдэг эрсдэл ихтэй өвчнүүд.

7. Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг:

Хөдөлмөрийн чадвараа гэнэт алдах шалтгаан болохуйц бодисын солилцооны ба дотоод шүүрэл булчирхайн аливаа өвчин багтана.

(а) чихрийн шижин өвчтэй боловч:

- 1/ энэ өвчний эсрэг ямар нэгэн эм бэлдмэл хэрэглэлгүй биеийн байдал нь хэвийн хадгалагдаж байвал;
- 2/ мөн чихрийн шижингийн эсрэг эм бэлдмэлийг ууж хэрэглэдэг /инсулин эмчилгээ хэрэглэдэггүй ба ууж хэрэглэдэг эм бэлдмэлийг хувь хүний онцлогт тохируулан эмчийн хяналтан дор хэрэглэдэг/ бол тухайн этгээдийг эрүүл мэндийн тэнцэнэ гэж үзнэ.

(б) таргалалтын 2 дугаар зэрэг болон түүнээс дээш зэрэг. /БЖИ \geq 34/

8. Цус, дархлалын тогтолцооны эмгэг:

Цус ба дархлалын тогтолцооны аливаа идэвхитэй хэлбэрийн өвчин багтана:

- (а) цус төлжүүлэх эмгэг /миелопротоператив/ болон халдварын шалтгаант дэлүү томрох;
- (б) хэсэг газрын болон бүх биеийн тунгалагийн булчирхай томрох;
- (в) цус, цусны эсүүдийн зарим эмгэгүүд;
- (г) дархлал дарангуйлдаг болон дархлал хэт идэвхжүүлдэг эмгэгүүд орно.

Цус, дархлалын тогтолцооны архаг өвчтэй боловч өвчин намдалтын үедээ байгаа бөгөөд мэргэжлийн дагуу эрх үүргээ биелүүлэхэд саадгүй болох нь нарийн мэргэжлийн эмчийн дүгнэлтээр батлагдсан бол тухайн этгээдийг эрүүл мэндийн хувьд тэнцэнэ гэж үзнэ. Ямар нэгэн халдварт өвчтэй бөгөөд энэ нь ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд нь сөргөөр нөлөөлдөг, эсхүл хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэдэг бол зохих эмчилгээ хийлгэж эдгэрэхээс нааш тухайн этгээдийг эрүүл мэндийн хувьд тэнцэхгүйд тооцно.

9. Шээс бэлгийн замын өвчин:

Мэргэжлийн ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд сөрөг нөлөө үзүүлж, хөдөлмөрийн чадвараа гэнэт алдах шалтгаан болохуйц шээс, бэлгийн замын аливаа өвчин эмгэг, эсхүл мэс засал, гэмтлээс үүдэлтэй шээс бэлгийн замын эрхтэн тогтолцооны эмгэг болон бөөр шээсний замын хаагдалт үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлүүд багтана. Ийм өвчний онош тавигдсан өргөдөл гаргагчийг эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй гэж үзнэ.

10. Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны эмгэг:

- (а) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал;
- (б) жирэмслэлт;
- (в) нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны эмгэгтэй болон урьд нь ийм өвчнөөр өвдөж байсан түүхгүй байх.

11. Хараанд тавигдах шаардлага:

- (а) мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахуйц, нүд ба түүний дайврын төрөлхийн болон олдмол гажиг, хурц ба архаг эмгэг;
- (б) харааны талбайн болон хос харааны гүнзгий өөрчлөлт;
- (в) нүдний булчингийн тэнцвэр ихээр алдагдах буюу солир харах эмгэг (хялар); Нүдний

булчингийн агших чадвар нь экзофори үед 12 диоптри, эзофори үед 6 диоптри, гиперфори үед 1 диоптроор засагдвал тэнцэнэ гэж үзнэ.

(г) анатомийн болон үйл ажиллагаа нь алдагдсан нэг нүд /монокуляр хараа/ ба нэг нүдний хэвийн бус хараа.

12. Ойрын болон дундын хараа:

Өргөдөл гаргагч нь N5-ын дүрсийг 33 см-ийн зайнаас, N14-ийн дүрсийг 100 см-ийн зайнаас харж унших чадвартай байна. Эсхүл дурдсан зай (33см-ийн зайнаас 6/12, 20/40-ийг, 100см-ийн зайнаас 6/24 ба 20/80-ыг/-наас харах чадвартай байна. Нүдний шилний тусламжтайгаар дээрх шаардлагыг хангасан этгээдэд гэрчилгээ олгож болно. Хэрэв шил зүүх шаардлагатай бол ойрын болон дундын харааны талласан бифокус /давхар хараатай/ шил зүүхийг шаардана.

13. Холын хараа:

Өргөдөл гаргагчийн холын хараа нь шилтэй буюу шилгүй 0,6-аас дээш, эсхүл энэ нь хоёр нүдэнд ижил (20/30, 0,66) байна. Дээрх шаардлагыг нүдний шилний тусламжтайгаар хангасан этгээдэд гэрчилгээ олгохдоо үргэлж шил зүүхийг шаардана. Өргөдөл гаргагчийн холын хараа нь 6/36-д хүрэхгүй буюу 20/120, 0,12 хэмжээтэй, эсхүл түүнээс бага бол холын харааны шил зүүнэ. Нүдний харааг шалгах бүрдээ шилгүй болон шилтэй шалгаж тэмдэглэсэн байна.

14. Хол болон ойрын хараа:

Холын болон ойрын харааг засах шаардлагатай этгээдийг тохирсон шил зүүхийг шаардана. Холын болон ойрын харааг засах шаардлагатай этгээд хүчинтэй гэрчилгээтэй байна. 2 болон 3 фокуст шилийг заавал зүүнэ. Баталгаанд хамаарах зүйлүүд:

(а) тал нүдний шил ба бифокал шил зүүсэн байна;

(б) контактны линз зүүхийг зөвшөөрсөн, эсхүл ойрын хараагаа засах шаардлагатай бол тал нүдний шил заавал зүүх, эсхүл хязгаарлалттай 2 фокуст нүдний шил зүүнэ гэсэн эмнэлгийн дүгнэлттэй байна.

15. Контакт линз:

Энэ стандартыг хангахын тулд зөвхөн эмнэлгийн дүгнэлтээр холын харааны контакт линз хэрэглэхийг зөвшөөрнө. Линз нь харах зайнаас хамаарна (линз зүүгээд харах зай нь нүдний шил зүүгээд харах зайтай адил байвал зохино). Зөвхөн харааг засахаас бусад тохиолдолд уг линзийг хэрэглэхийг энэ Хавсралтын 14-т зааснаар зохицуулна.

16. Диоптрийн хязгаарлалт (линзийг хэмжих нэгж):

Хоёр нүдэнд тохирсон линз нь ± 3 диоптрийн хэмжээний хооронд хүлээн зөвшөөрөгдсөн байна. Мөн шилгүй хараа нь 6/60 хэмжээнээс доошгүй, эсхүл энэ нь (20/200, 0,1) 2 нүдэнд ижил байна. Энэ хэмжээнээс доогуур нүдний шилний линз байх боломжгүй боловч эмнэлгээс зөвшөөрөгдсөн тухайн этгээдийн хэрэглэдэг контактны линз нь мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхэд тохирсон бөгөөд гэрчилгээнд зөвшөөрөгдсөн байна. Контакт линзийг, эсхүл нэмэгдэл шил зүүнэ. Гэхдээ нэмэгдэл шилийг зөвхөн онцгой тохиолдолд хэрэглэнэ.

17. Өнгө ялгах чадвар:

Өргөдөл гаргагч нь ажил үүргээ хэвийн гүйцэтгэхийн тулд өнгө ялгах чадвартай байна. Бууралттай линз зүүхийг зөвшөөрөхгүй. Хэрэв гэрчилгээ эзэмшигч нь өнгө мэдрэмжийн бага зэргийн гажигтай бол гэрчилгээнд дараах хязгаарлалтыг тусгана:

(а) шөнийн нислэг үйлдэхийг зөвшөөрөхгүй;

(б) хяналттай аэродром орчимд нислэг үйлдэхийг зөвшөөрөхгүй /хэрэв агаарын хөлөг нь радио холбоогүй бол/;

(в) зорчигч тээвэрлэхийг зөвшөөрөхгүй.

Тайлбар: Зөвхөн эмнэлгийн тусгай үзлэгийн дүгнэлтийг үндэслэн дээрх хязгаарлалтыг хүчингүй болгоно.

18. Чих хамар хоолой, сонсгол:

Өргөдөл гаргагч дараах өвчин эмгэггүй байна:

(а) гадна, дунд, дотор, чихний хөндийн цочмог болон архаг эмгэг;

(б) евстахиевийн сувгийн архаг болон дахилттай битүүрэл;

(в) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хүндрэлтэй болон дахилттай эмгэгүүд;

(г) шүд, ам, хамрын дайвар хөндийн ба амьсгалын дээд замын төрөлхийн гажиг болон зарим өвчнүүд;

(д) мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхэд саад болохуйц хэл ярианы согог.

19. Сонсголын бичлэг

2 жил тутам хийлгэх шаардлагатай бөгөөд тухайн этгээдийн сонсох чадварын алдагдал нь 500, 1000, 1500, 2000 Гц-ийн давтамж тус бүрт 35 дБ-ээс хэтрэхгүй байх, эсхүл 3000 Гц-д 50 дБ-ээс хэтрэхгүй байна. Хэрэв аль нэг чихний сонсох чадварын алдагдал нь давтамж тус бүрт тогтоосон хязгаараас хэтрээгүй бол тэнцэнэ гэж үзэх бөгөөд ярианы аудиометрээр шалгахад 90%-иас доошгүй үзүүлэлттэй байна.

20. Зүрхний цахилгаан бичлэг:

Эрүүл мэндийн 1 дүгээр ангиллын гэрчилгээ эхлэн олгоход зүрхний цахилгаан бичлэгийг анхны үзлэгээс хойш зүрх судасны өвчний оношгүй бол жил бүр хийх ба 40-өөс дээш насанд жилд 2 удаа хийнэ.

ХАВСРАЛТ “Б”

ЭРҮҮЛ МЭНДИЙН 2 ДУГААР АНГИЛЛЫН ГЭРЧИЛГЭЭ АВАХААР ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

Эрүүл мэндийн 2 дугаар ангиллын гэрчилгээ авахаар Өргөдөл гаргагчид ИНД-67.101-д заасан ерөнхий шаардлага болон энэ Хавсралтад заасан шаардлагууд тавигдана.

1. Сэтгэц мэдрэлийн эмгэг:

(а) бүрэн эмчлэгдсэн хордлогын шалтгаантайгаас бусад, сэтгэл мэдрэлийн хурц эмгэг (психоз), солиорол;

(б) согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг, эсхүл түүнээс хамааралтай байдалд орсон (биеийн эрүүл мэнд болон ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд нь сөргөөр нөлөөлөх хэмжээний архи хэрэглэдэг болох нь тогтоогдсон);

(в) эмийн бодисоос хамааралтай байдал /эмийн тусламжтайгаар хэвийн байдлаа хадгалах г.м./;

(г) зан төрхийн өөрчлөлт орсон, тэр нь ямар нэг байдлаар илэрдэг;

(д) сэтгэцийн хэвийн бус байдал, хүнд хэлбэрийн психоневроз;

(е) сэтгэл гутрал, депресс.

Өргөдөл гаргагч нь энэ хэсгийн (а)-(е)-д дурдсан өвчний аль нэгээр өвчний түүх нээлгэсэн боловч эмчлүүлээгүй, онош нь бүрэн батлагдаагүй нөхцөлд нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл 2 жилийн хугацаанд оношийг бүрэн батлах нарийн шинжилгээ хийлгэх ба энэ хугацаанд “түр тэнцэхгүй” гэж үзнэ.

Архины цагаан солиотой гэсэн оноштой, эсхүл согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэдэг этгээдээс бусад өргөдөл гаргагч нь шинжээч эмчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байвал дараах шаардлагыг хангасан тохиолдолд 67.17 (г)-д заасны дагуу Эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээдийн дүгнэлт, хязгаарлалтыг хянаж үзэхийг ИНЕГ-аас хүсэх эрхтэй:

- архины эмчилгээ хийгдсэний дараа тухайн этгээд бүрэн эмчлэгдсэн тухай нарколог эмч баталгаа гаргасан;

- нислэг үйлдэх эрхээ авсан хугацаанд согтууруулах ундаа хэрэглэхгүй гэсэн баталгаа гаргасан.

2. Мэдрэлийн өвчин:

(а) татаж унадаг өвчин /эпилепси/;

(б) үе үе ухаан алддаг;

(в) мигрень /толгой таллаж өвдөх/ болон бусад хүнд хэлбэрийн толгойн өвдөлтүүд;

(г) тархи нугасны гэмтэл болон мэс заслын үлдэц нөлөө нь эрх үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулахуйц байвал.

3. Яс тулагуур эрхтэнтогтолцооны эмгэг:

Яс, арьс, үе, булчин, холбогч эд, шөрмөсний ямар нэг өвчний идэвхитэй хэлбэр, төрөлхийн болон гэмтэл, мэс заслаас үүдэлтэй яс, үе, булчин, шөрмөс, холбогч эдийн өвчний улмаас үүссэн бие махбодийн үйл ажиллагааны хэвийн бус байдал багтана.

4. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг:

Хоол боловсруулах эрхтнүүд, элэгний үйл ажиллагааг их хэмжээгээр алдагдуулсан архаг ба хурц өвчин эмгэгүүд, халдварт өвчнүүд, хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэдэг аливаа эмгэг, гэмтлээс үүдэлтэй эмгэг болон хагалгааны дараах байдал, ивэрхий багтана.

5. Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг:

Цээжний хөндийн ямар нэг хурц, идэвхитэй хэлбэрийн өвчин, гэмтэл, уушиг, уушигны гялтан хальс, амьсгалын замын ямар нэгэн халдвар, өндөрт нисэх үед хөдөлмөрийн чадвар гэнэт алдагдах шалтгаан болохуйц аливаа өвчин эмгэг /*гуурсан хоолойн багтраа гэх мэт* / эсхүл хагалгаа багтана. Эрүүл мэндийн 2 дугаар ангиллын гэрчилгээ эхлэн авахын тулд рентген шинжилгээ зайлшгүй хийлгэх шаардлагатай.

6. Зүрх судасны эмгэг:

Зүрх, цусны эргэлтийн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал бүхий дараах өвчин эмгэгүүд:

(а) зүрхний бах, шигдээс, хүндэрсэн хэлбэрийн цусны даралт ихсэлт;

(б) зүрхний хэмнэл алдагдах /пейсмейкер шаардлагатай/;

(в) зүрхний булчингийн агших чадвар сулрах;

(г) зүрхний титэм судасны эмгэг;

(д) зүрхний булчингийн, хавхлагийн, дамжуулах тогтолцооны эмгэг;

(е) гиссийн багцны зүүн, баруун салааны хориг;

(ж) эмчилгээний үр дүн муутай зүрхний дутагдал буюу хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэдэг эрсдэлт ихтэй өвчнүүд.

7. Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг:

Хөдөлмөрийн чадвараа гэнэт алдах шалтгаан болохуйц бодисын солилцооны ба дотоод шүүрэл булчирхайн аливаа өвчин багтана.

(а) Чихрийн шижин өвчтэй боловч:

1/ энэ өвчний эсрэг ямар нэгэн эм бэлдмэл хэрэглэлгүй биеийн байдал нь хэвийн хадгалагдаж байвал;

2/ мөн чихрийн шижингийн эсрэг эм бэлдмэлийг ууж хэрэглэдэг /инсулин эмчилгээ хэрэглэдэггүй ба ууж хэрэглэдэг эм бэлдмэлийг хувь хүний онцлогт тохируулан эмчийн хяналтан дор хэрэглэдэг/ бол тухайн этгээдийг эрүүл мэндийн хувьд тэнцэнэ гэж үзнэ.

(б) Таргалалтын 2 дугаар зэрэг болон түүнээс дээш зэрэг. /БЖИ \geq 34/

8. Цус, дархлалын тогтолцооны эмгэг:

Цус ба дархлалын тогтолцооны аливаа идэвхитэй хэлбэрийн өвчин багтана. Үүнд:

(а) цус төлжүүлэх эмгэг /миелопротоператив/ болон халдварын шалтгаант дэлүү томрох;

(б) хэсэг газрын болон бүх биеийн тунгалагийн булчирхай томрох;

(в) цус, цусны эсүүдийн зарим эмгэгүүд;

(г) дархлал дарангуйлдаг болон дархлал хэт идэвхижүүлдэг эмгэгүүд орно.

Цус, дархлалын тогтолцооны архаг өвчтэй боловч өвчин намдалтын үедээ байгаа бөгөөд мэргэжлийн дагуу үүргээ биелүүлэхэд саадгүй болох нь нарийн мэргэжлийн эмчээр батлагдсан бол тухайн этгээдийг эрүүл мэндийн хувьд тэнцэнэ гэж үзнэ. Ямар нэгэн халдварт өвчтэй бөгөөд энэ нь ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд нь сөргөөр нөлөөлдөг, эсхүл хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэдэг бол зохих эмчилгээ хийлгэж эдгэрэхээс нааш тухайн этгээдийг эрүүл мэндийн хувьд тэнцэхгүйд тооцно.

9. Шээс бэлгийн замын өвчин:

Мэргэжлийн ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд сөрөг нөлөө үзүүлж, хөдөлмөрийн чадвараа гэнэт алдах шалтгаан болохуйц шээс, бэлгийн замын аливаа өвчин эмгэг, эсхүл мэс засал, гэмтлээс үүдэлтэй шээс бэлгийн замын эрхтэн тогтолцооны эмгэг болон бөөр шээсний замын хаагдалт үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлүүд багтана. Ийм өвчний онош тавигдсан өргөдөл гаргагчийг эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй гэж үзнэ.

10. Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны эмгэг:

(а) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал;

(б) жирэмслэлт;

(в) нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны эмгэгтэй болон урд нь ийм өвчнөөр өвдөж байсан түүхгүй байх.

11. Хараа:

(а) мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахуйц, нүд ба түүний дайврын төрөлхийн болон олдмол гажиг, хурц ба архаг эмгэг;

(б) харааны талбайн болон хос харааны гүнзгий өөрчлөлт;

(в) нүдний булчингийн тэнцвэр ихээр алдагдах буюу солир харах эмгэг (хялар). Нүдний булчингийн агших чадвар нь экзофори үед 12 диоптри, эзофори үед 6 диоптри, гиперфори үед 1 диоптроор засагдвал тэнцэнэ гэж үзнэ.

(г) анатомийн болон үйл ажиллагаа нь алдагдсан нэг нүд /монокуляр хараа/ ба нэг нүдний хэвийн бус хараа /эрүүл мэндийн 2 дугаар ангиллын гэрчилгээ эхлэн олгоход тавигдах шаардлагын дагуу/. Нэг нүднийхээ тусламжтайгаар ажиллах чадвар, дадал эзэмшсэн этгээдэд ажлын нөхцөлд нь тохируулан тодорхой хугацаанд зохих хязгаарлалттай гэрчилгээ олгохоор эмнэлгийн дүгнэлт гаргаж болно. Нэг нүд /монокуляр хараа/ гэдэг нь өрөөсөн нүдгүй, эсхүл уг нүдний хараа нь шилээр 6/60 /0,1/-аас дээш засагдахгүй байхыг хэлнэ. Нэг нүдний хэвийн бус хараа гэдэг нь төвийн хараа 6/60-аас дээш, 6/9-өөс доош байхыг хэлнэ.

Монокуляр хараатай этгээдээс дараах хязгаарлалтыг шаардана:

- хамгаалах шил заавал зүүх /задгай бүхээгтэй онгоцоор нисэх тохиолдолд харааны талбайг хязгаарлахгүй шил зүүнэ/. Энэ нь байнгын хязгаарлалт байна;
- хамтран нисгэгч нь монокуляр хараатай болохыг нөгөө нисгэгчид мэдэгдсэн байх;
- монокуляр хараатай этгээдийн хувьд өдөр ба шөнийн нислэгийн шалгалтыг хангалттай дүнтэй өгсөн байх.

12. Ойрын болон дундын хараа:

Өргөдөл гаргагч нь N5-ын дүрсийг 33 см-ийн зайнаас, N14-ийн дүрсийг 100 см-ийн зайнаас харж унших чадвартай байна. Эсхүл дурдсан зай (33см-ийн зайнаас 6/12, 20/40-ийг, 100см-ийн зайнаас 6/24 ба 20/80-ыг/-наас харах чадвартай байна. Нүдний шилний тусламжтайгаар дээрх стандартыг хангасан этгээдэд гэрчилгээ олгож болно. Хэрэв шил зүүх шаардлагатай бол ойрын болон дундын харааны талласан бифокус /давхар хараатай/ шил зүүхийг шаардана.

13. Холын хараа:

Өргөдөл гаргагчийн холын хараа нь шилтэй буюу шилгүй 0,6-аас дээш, эсхүл энэ нь хоёр нүдэнд ижил (20/30, 0,66) байна. Дээрх стандартыг нүдний шилний тусламжтайгаар хангасан этгээдэд гэрчилгээ олгохдоо үргэлж шил зүүхийг шаардана. Өргөдөл гаргагчийн холын хараа нь 6/36-д хүрэхгүй буюу 20/120, 0,12 хэмжээтэй, эсхүл түүнээс бага бол холын харааны шил зүүнэ. Нүдний харааг шалгах бүрдээ шилгүй болон шилтэй шалгаж тэмдэглэсэн байна.

14. Хол болон ойрын хараа:

Холын болон ойрын харааг засах шаардлагатай этгээдийг тохирсон шил зүүхийг шаардана. Холын болон ойрын харааг засах шаардлагатай этгээд хүчинтэй гэрчилгээтэй байна. 2 болон 3 фокуст шилийг заавал зүүнэ. Баталгаанд хамаарах зүйлүүд:

(а) тал нүдний шил ба бифокал шил зүүсэн байна;

(б) контактны линз зүүхийг зөвшөөрсөн, эсхүл ойрын хараагаа засах шаардлагатай бол тал нүдний шил заавал зүүх, эсхүл хязгаарлалттай 2 фокуст нүдний шил зүүнэ гэсэн эмнэлгийн дүгнэлттэй байна.

15. Контакт линз:

Энэ стандартыг хангахын тулд зөвхөн эмнэлгийн дүгнэлтээр холын харааны контакт линз хэрэглэхийг зөвшөөрнө. Линз нь харах зайнаас хамаарна (линз зүүгээд харах зай нь нүдний шил зүүгээд харах зайтай адил байвал зохино). Зөвхөн харааг засахаас бусад тохиолдолд уг линзийг хэрэглэхийг энэ Хавсралтын 14-т зааснаар зохицуулна.

16. Диоптрийн хязгаарлалт (линзийг хэмжих нэгж):

Хоёр нүдэнд тохирсон линз нь ± 3 диоптрийн хэмжээний хооронд хүлээн зөвшөөрөгдсөн байна. Мөн шилгүй хараа нь 6/60 хэмжээнээс доошгүй, эсхүл энэ нь (20/200, 0,1) 2 нүдэнд ижил байна. Энэ хэмжээнээс доогуур нүдний шилний линз байх боломжгүй боловч эмнэлгээс зөвшөөрөгдсөн тухайн этгээдийн хэрэглэдэг контактны линз нь мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхэд тохирсон байх бөгөөд гэрчилгээнд зөвшөөрөгдсөн байна. Контакт линз, эсхүл нэмэгдэл шил зүүнэ. Гэхдээ нэмэгдэл шилийг зөвхөн онцгой тохиолдолд хэрэглэнэ.

17. Өнгө ялгах чадвар:

Өргөдөл гаргагч нь ажил үүргээ хэвийн гүйцэтгэх шаардлагаар өнгө ялгах чадвартай байна. Бууралттай линз зүүхийг зөвшөөрөхгүй. Хэрэв гэрчилгээ эзэмшигч нь өнгө мэдрэмжийн бага зэргийн гажигтай бол гэрчилгээнд дараах хязгаарлалтыг тусгана:

(а) шөнийн нислэг үйлдэхийг зөвшөөрөхгүй;

(б) хяналттай аэродром орчимд нислэг үйлдэхийг зөвшөөрөхгүй /хэрэвагаарын хөлөг нь радио холбоогүй бол/;

(в) зорчигч тээвэрлэхийг зөвшөөрөхгүй.

Тайлбар: Зөвхөн эмнэлгийн тусгай үзлэгийн дүгнэлтийг үндэслэж дээрх хязгаарлалтыг хүчингүй болгоно.

18. Чих хамар хоолой, сонсгол:

(а) гадна, дотор, дунд чихний хөндийн цочмог болон архаг эмгэг;

(б) евстахиевийн сувгийн архаг болон дахилттай битүүрэл;

(в) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хүндрэлтэй болон дахилттай эмгэгүүд;

(г) шүд, ам, хамрын дайвар хөндийн ба амьсгалын дээд замын төрөлхийн гажиг болон зарим өвчнүүд;

(д) мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхэд саад болохуйц хэл ярианы согог;

(е) өргөдөл гаргагч нь чимээ шуугиангүй тасалгаанд, шалгагчийг харахгүйгээр, сонсголын аппарат хэрэглэхгүйгээр шалгагчийн ярьж буй зүйлийг 2м-ийн зайнаас сонсох чадвартай байна. Энэ сорилд тэнцээгүй этгээд чих, хамар хоолойн эмчид үзүүлж, сонсголын бичлэг (аудиограмм) хийлгэнэ.

19. Хувийн нисгэгчийн үнэмлэхтэй 40 хүртэлх насны нисгэгч 4 жил тутамд, 40-өөс дээш насанд 2 жил тутамд сонсголын бичлэг (аудиометр) хийлгэнэ. Өргөдөл гаргагч 35 Дб-ээс дээш давтамжтай 500, 1000, 1500, 2000 Гц буюу 50 Дб-ээс дээш буюу 3000Гц-ийг 2 чихээрээ сонсох чадвартай байна. Өргөдөл гаргагчийн аль нэг чихний сонсгол дээрх стандартыг хангаж чадахгүй бол давтамж бүрийн дундаж хязгаараас хэтрээгүй үед сул сонсголд тохирсон өөр аргыг хэрэглэх ба тухайн тестийг 90 ба түүнээс дээш үзүүлэлтээр хангаж байх шаардлагатай.

20. Зүрхний цахилгаан бичлэг:

Эрүүл мэндийн 2 дугаар ангиллын гэрчилгээ эхлэн олгоход зүрхний цахилгаан бичлэгийг анхны үзлэгээс хойш зүрх судасны өвчний оношгүй бол 40, 44, 48, 52, 54, 56, 58, 60 насанд хийх ба 60-аас дээш насанд жил бүр хийнэ.

---oOo--

ХАВСРАЛТ “В”

ЭРҮҮЛ МЭНДИЙН 3 ДУГААР АНГИЛЛЫН ГЭРЧИЛГЭЭ АВАХААР ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

Эрүүл мэндийн 3 дугаар ангиллын гэрчилгээ авахаар Өргөдөл гаргагчид ИНД-67.101-д заасан ерөнхий шаардлага болон энэ Хавсралтад заасан шаардлагууд тавигдана.

1. Сэтгэл мэдрэлийн өвчин:

(а) бүрэн эмчлэгдсэн хордлогын шалтгаантайгаас бусад, сэтгэл мэдрэлийн хурц эмгэг (психоз), солиорол;

(б) согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг, эсхүл түүнээс хамааралтай байдалд орсон (биеийн эрүүл мэнд болон ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд нь сөргөөр нөлөөлөх хэмжээний архи хэрэглэдэг болох нь тогтоогдсон);

(в) эмийн бодисоос хамааралтай байдал /эмийн тусламжтайгаар хэвийн байдлаа хадгалах г.м./;

(г) зан төрхийн өөрчлөлт орсон, тэр нь ямар нэг байдлаар илэрдэг;

(д) сэтгэцийн хэвийн бус байдал, хүнд хэлбэрийн психоневроз;

(е) сэтгэл гутрал, депресс.

Өргөдөл гаргагч нь дээрх оношийн аль нэгээр өвчний түүх нээлгэсэн боловч эмчлүүлээгүй, онош нь бүрэн батлагдаагүй нөхцөлд нислэгийн аюулгүй байдлын ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл 2 жилийн хугацаанд оношийг бүрэн батлах нарийн шинжилгээ хийлгэх ба энэ хугацаанд “түр тэнцэхгүй” гэж үзнэ.

Архины цагаан солиотой гэсэн оноштой, эсхүл согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэдэг этгээдээс бусад өргөдөл гаргагч нь шинжээч эмчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байвал дараах шаардлагыг хангасан тохиолдолд 67.105 (г)-д заасны дагуу эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий этгээдийн дүгнэлт, хязгаарлалтыг хянаж үзэхийг ИНЕГ-аас хүсэх эрхтэй:

- архины эмчилгээ хийгдсэний дараа тухайн этгээд бүрэн эмчлэгдсэн тухай нарколог эмч баталгаа гаргасан;

- нислэгийн хөдөлгөөнийг удирдах эрх авсан хугацаандаа согтууруулах ундаа хэрэглэхгүй гэсэн баталгаа гаргасан.

2. Мэдрэлийн өвчин:

(а) татаж унадаг өвчин /эпилепси/;

(б) үе үе ухаан алддаг;

(в) мигрень /толгой таллаж өвдөх/ болон бусад хүнд хэлбэрийн толгойн өвдөлтүүд;

(г) тархи нугасны хүнд гэмтэл болон мэс заслын үлдэц нөлөө нь эрх үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулахуйц байвал.

3. Яс, тулгуур эрхтэн тогтолцооны эмгэгүүд:

Яс, *арьс*, үе, булчин, *холбогч эд*, шөрмөсний ямар нэг өвчний идэвхитэй хэлбэр, төрөлхийн болон гэмтэл, мэс заслаас үүдэлтэй яс, үе, булчин, шөрмөс, холбогч эдийн өвчний улмаас үүссэн бие махбодийн үйл ажиллагааны хэвийн бус байдал багтана.

4. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг:

Хоол боловсруулах эрхтнүүд, элэгний үйл ажиллагааг их хэмжээгээр алдагдуулсан архаг ба хурц өвчин эмгэгүүд, халдварт өвчнүүд, хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэдэг аливаа эмгэг, гэмтлээс үүдэлтэй эмгэг болон хагалгааны дараах байдал, ивэрхий багтана.

5. Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг:

Цээжний хөндийн ямар нэг хурц, идэвхитэй хэлбэрийн өвчин, гэмтэл, уушиг, уушигны гялтан хальс, амьсгалын замын ямар нэгэн халдвар, хөдөлмөрийн чадвар гэнэт алдагдах шалтгаан болохуйц аливаа өвчин эмгэг /*гуурсан хоолойн багтраа гэх мэт*/, эсхүл хагалгаа багтана. 3-р ангиллын гэрчилгээ эхлэн олгохын тулд рентген шинжилгээ зайлшгүй шаардлагатай.

6. Зүрх судасны эмгэгүүд:

Зүрх, цусны эргэлтийн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал бүхий дараах өвчин эмгэгүүд:

(а) зүрхний бах, шигдээс, хүндэрсэн хэлбэрийн цусны даралт ихсэлт;

(б) зүрхний хэмнэл алдагдах /пейсмейкер шаардлагатай/;

(в) зүрхний булчингийн агших чадвар сулрах;

(г) зүрхний титэм судасны эмгэг;

(д) зүрхний булчингийн, хавхлагийн, дамжуулах тогтолцооны эмгэг;

(е) гиссийн багцны зүүн салааны хориг;

(ж) эмчилгээний үр дүн муутай зүрхний дутагдал буюу хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэдэг эрсдэлт ихтэй өвчнүүд.

7. Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг:

Хөдөлмөрийн чадвараа гэнэт алдах шалтгаан болохуйц бодисын солилцооны ба дотоод шүүрлийн булчирхайн аливаа өвчин багтана.

(а) чихрийн шижин өвчтэй боловч:

1/ энэ өвчний эсрэг ямар нэгэн эм бэлдмэл хэрэглэлгүй биеийн байдал нь хэвийн хадгалагдаж байвал;

2/ мөн чихрийн шижингийн эсрэг эм бэлдмэлийг ууж хэрэглэдэг /инсулин эмчилгээ хэрэглэдэггүй ба ууж хэрэглэдэг эм бэлдмэлийг хувь хүний онцлогт тохируулан эмчийн хяналтан дор хэрэглэдэг/ бол тухайн этгээдийг эрүүл мэндийн хувьд тэнцэнэ гэж үзнэ.

(б) Таргалалтын 2 дугаар зэрэг ба түүнээс дээш /БЖИ \geq 34/

8. Цус, дархлалын тогтолцооны эмгэг:

Цус ба дархлалын тогтолцооны аливаа идэвхитэй хэлбэрийн өвчин багтана:

(а) миелополиператив болон халдварын шалтгаант дэлүү томрох /спленомегали/;

(б) хэсэг газрын болон бүх биеийн тунгалагийн булчирхай томрох;

(в) цус, цусны эсүүдийн зарим эмгэгүүд;

(г) дархлал дарангуйлдаг болон дархлал хэт идэвхижүүлдэг эмгэгүүд орно.

Цус, дархлалын тогтолцооны архаг өвчтэй боловч өвчин намдалтын үедээ байгаа бөгөөд мэргэжлийн дагуу эрх үүргээ биелүүлэхэд саадгүй болох нь нарийн мэргэжлийн эмчээр батлагдсан бол тухайн этгээдийг эрүүл мэндийн хувьд тэнцэнэ гэж үзнэ. Ямар нэгэн халдварт өвчтэй бөгөөд энэ нь ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд нь сөргөөр нөлөөлдөг, эсхүл хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэдэг бол зохих эмчилгээ хийлгэж эдгэрэхээс нааш тухайн этгээдийг эрүүл мэндийн хувьд тэнцэхгүйд тооцно.

9. Шээс, бэлгийн замын өвчин:

Мэргэжлийн үүргээ хэвийн гүйцэтгэхэд сөрөг нөлөө үзүүлж, хөдөлмөрийн чадвараа гэнэт алдах шалтгаан болохуйц шээс, бэлгийн замын аливаа өвчин эмгэг, эсхүл мэс засал болон гэмтлээс үүдэлтэй шээс бэлгийн замын эрхтэн тогтолцооны, бөөр шээсний замын хаагдалт үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлүүд багтана. Ийм өвчний онош тавигдсан өргөдөл гаргагчийг эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй гэж үзнэ.

10. Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны эмгэг:

(а) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал;

(б) жирэмслэлт;

(в) нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны эмгэгтэй болон урд нь ийм өвчнөөр өвдөж байсан түүхгүй байх.

11. Хараа:

(а) мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахуйц, нүд ба түүний дайврын төрөлхийн болон олдмол гажиг, хурц ба архаг эмгэг;

(б) харааны талбайн болон хос харааны өөрчлөлт;

(в) нүдний булчингийн тэнцвэр ихээр алдагдах буюу солир харах эмгэг (хялар). Нүдний булчингийн агших чадвар нь экзофори үед призм шилээр 12 диоптри, эзофори үед 6 диоптри, гиперфори үед 1 диоптроор засагдвал тэнцэнэ гэж үзнэ.

(г) эрүүл мэндийн 3 дугаар ангиллын гэрчилгээг эхлэн олгоход тавигдах шаардлагын дагуу анатомийн болон үйл ажиллагаа нь алдагдсан нэг нүд (монокуляр хараа ба нэг нүдний хэвийн бус хараа). Нэг нүднийхээ тусламжтай ажиллах чадвар, дадал сайтай этгээдэд ажлын нөхцөлд нь тохируулан тодорхой хугацаанд зохих хязгаарлалттай гэрчилгээ олгохоор эмнэлгийн дүгнэлт гаргаж болно. Нэг нүд /монокуляр хараа/ гэдэг нь өрөөсөн нүдгүй, эсхүл уг нүдний хараа нь шилээр 6/60 (0,1)-аас дээш засагдахгүй байхыг хэлнэ.

12. Ойрын болон дундын хараа:

Өргөдөл гаргагч нь N5-ын дүрсийг 33 см-ийн зайнаас, N14-ийн дүрсийг 100 см-ийн зайнаас харж унших чадвартай байх, эсхүл дурдсан зай (33 см-ийн зайнаас 6/12, 20/40-ийг, 100 см-ийн зайнаас 6/24 ба 20/80-ыг)-наас харах чадвартай байна. Нүдний шилний тусламжтайгаар дээрх шаардлагыг хангасан этгээдэд гэрчилгээ олгож болно. Гэхдээ ойрын харааны шил нь хол харах чадварыг үлэмж бууруулдаг тул ойрын харааны шил хэрэглэдэг этгээдийг хяналтын цамхагт ажиллуулахгүй. Бүтэн линзтэй этгээдэд локаторын өрөөнд ажиллахыг зөвшөөрнө. Өргөдөл гаргагчийн, тохирсон шилтэйгээр ажиллах /унших/ чадварыг тухайн ажлын байран дээр нь шалгана.

13. Холын хараа:

Өргөдөл гаргагчийн холын хараа нь шилгүй буюу шилтэй 6/9-өөс доошгүй байх, эсхүл энэ нь хоёр нүдэнд ижил (20/30, 0,66) байна. Дээрх стандартыг нүдний шил (линз)-ний тусламжтайгаар хангасан этгээдэд гэрчилгээ олгохдоо үргэлж шил зүүхийг шаардана. Өргөдөл гаргагчийн хараа нь 6/36 хэмжээнд хүрэхгүй буюу 20/120, 0.12-оос муу бол холын харааны шил зүүнэ. Харааг шилгүй болон шилтэй шалгаж тэмдэглэсэн байна.

14. Холын болон ойрын харааг засах:

Холын хараагаа засах шаардлагатай этгээд 33 см-ээс илүүгүй зайд тохирсон хэмжээ бүхий шил зүүнэ. Холын болон ойрын харааг хавсарсан шилээр засах ба тухайн этгээд эмнэлгийн хүчинтэй гэрчилгээтэй байна. 2 болон 3 фокуст шил (трифокал)-ийг заавал зүүнэ. Баталгаанд хамаарах зүйлүүд:

(а) трифокал шилийг биедээ байнга авч явахыг шаардана;

(б) тал нүдний шил буюу бифокал шилтэйгээр уншиж чаддаг байна.

15. Контактны линз.

Зөвхөн холын харааг засах шаардлагатай тохиолдолд эмчийн зөвшөөрлөөр контакт линз зүүхийг зөвшөөрнө. Эмнэлгийн шаардлага нь зөвхөн холын харааны линз зөвшөөрөгдөнө.

16. Диоптрийн хязгаарлалт (линзийг хэмжих нэгж):

Хоёр нүдэнд тохирсон линз нь ± 3 диоптрийн хооронд хүлээн зөвшөөрөгдсөн байна. Мөн шилгүй хараа нь 6/60 хэмжээнээс доошгүй, эсхүл энэ нь (20/200, 0,1) 2 нүдэнд ижил байна. Эмнэлгийн шаардлага нь контакт линз, эсхүл нөөц шил зүүнэ.

Өнгө ялгах чадварт тавигдах шаардлага- Өргөдөл гаргагч нь ажил үүргээ хэвийн гүйцэтгэх шаардлагын үүднээс өнгө ялгах чадвартай байна. Бууралттай линз зүүхийг зөвшөөрөхгүй.

17. Чих, хамар хоолой, сонсгол:

(а) гадна, дотор, дунд чихний хөндийн цочмог болон архаг эмгэг;

(б) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хүндрэлтэй болон дахилттай эмгэгүүд;

(в) ам, шүд, хамрын дайвар хөндийн ба амьсгалын дээд замын төрөлхийн гажиг болон зарим өвчнүүд;

(г) мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхэд саад болохуйц хэл ярианы согог;

18. Сонсголын бичлэгийг 2 жил тутам хийлгэж байх шаардлагатай. Тухайн этгээдийн сонсох чадварын алдагдал нь 500, 1000, 1500, 2000 Гц-ийн давтамж тус бүрт 35дб-ээс хэтрэхгүй байх, эсхүл 3000 Гц-д 50 дб-ээс хэтрэхгүй байна. Хэрэв аль нэг чихний сонсох чадварын алдагдал нь давтамж тус бүрт тогтоосон хязгаараас хэтрээгүй бол тэнцэнэ гэж үзэх бөгөөд ярианы аудиометрээр шалгахад 90%-иас доошгүй үзүүлэлттэй байна.

19. Зүрхний цахилгаан бичлэг:

Эрүүл мэндийн 3 дугаар ангиллын гэрчилгээ эхлэн олгоход зүрхний цахилгаан бичлэгийг анхны үзлэгээс хойш зүрх судасны өвчний оношгүй бол 2 жил тутамд хийх ба 40-өөс дээш насанд жил бүр хийнэ.

---oOo---